



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2023/106/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn</p> <p>Аудитор: П.Цогзолмаа Утас: 263533 Цахим хаяг: tsogzolmaар@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Мүүрь Аудит ХХК-ийн захирал У.Оюунаа Цахим хаяг: Info@moore-mongolia.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн Газар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.15 № 07/1583

танай _____-ны № _____-т

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ү.ТӨМӨРХУЯГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 81,260.6 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:
Хөгжлийн банкны зээлийн өмнөх болон тайлант оны үндсэн төлөлт 80,982.4 сая төгрөгийг хугацаандаа төлөөгүй, авлага өглөгийн үлдэгдэл 267.0 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, цалинг 5.2 сая төгрөгөөр илүү тооцож олгосон зэрэг болно

Асуудлыг онцолсон хэсэг

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь Хөгжлийн банкны 2021, 2022 онд төлбөл зохих зээлийн үндсэн төлөлтийг төлөөгүйн улмаас 2022 онд 414.3 сая төгрөгийн нэмэгдүүлсэн хүү төлсөн. Энэ нь Төрийн захиргааны байгууллага эрчим хүч, дулааны үнэ тарифыг алдагдалтай тогтоож байгаатай холбоотой бөгөөд зохицуулалттай үнэ тарифыг мөрдөж байгаа үед зээлийг төлөх эдийн засгийн боломж хомс байна. Ийнхүү жил бүр төсөвт тусгагдаагүй өндөр хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөх нь эдийн засгийн хувьд үргүй зардал гарч мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд орлогыг 305,329.8 сая төгрөгөөр, зардлыг 335,420.5 сая төгрөг, алдагдлыг 30,090.7 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр 331,435.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 381,490.5 сая төгрөгийн зардал гарган, 50,054.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,045,731,174.07	5,888,802,930.45
1.1.2	Дансны авлага	31,334,225,715.66	17,094,405,120.97
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	1,785,466,804.08
1.1.4	Бусад авлага	469,889,846.23	724,378,120.67
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	19,376,776,761.65	29,111,125,951.02
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,649,758,280.72	6,629,612,254.27
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	61,876,381,778.33	61,233,791,181.46
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	912,358,875,809.05	872,114,260,839.25
1.2.2	Биет бус хөрөнгө	76,925,722,242.26	76,937,241,608.25
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	105,136,899.92	514,389,332.12
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	989,389,734,951.23	949,565,891,779.62
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,051,266,116,729.56	1,010,799,682,961.08
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	8,650,577,597.79	1,692,407,049.88
2.1.1.2	Цалингийн өглөг	5,964,378,732.01	5,298,260,381.88
2.1.1.3	Татварын өр	1,355,387,449.54	1,009,934,929.72
2.1.1.4	НДШ – ийн өглөг	945,000,000.00	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	74,597,989,845.30	143,091,087,448.37
2.1.1.6	Хүүгийн өглөг	7,080,411,925.72	818,874,830.22
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	942,139,358.69	1,003,819,608.62
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	1,606,419,976.94	1,146,722,448.25
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,169,675,884.30	845,606,920.69

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	102,311,980,770.29	154,906,713,617.63
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	325,797,067,292.37	289,995,706,305.56
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	9,318,690,994.43	13,059,122,758.46
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	13,933,080,225.28	8,356,560,857.11
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5	Хойшлогдсон орлого	18,877,481,320.45	17,926,910,170.01
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	367,926,319,832.53	329,338,300,091.14
2.2	Өр төлбөрийн нийт дүн	470,238,300,602.82	484,245,013,708.77
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	227,071,740,030.34	227,071,740,030.34
2.3.2	хувийн	-	-
2.3.3	хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	311,515,695,204.19	257,661,148,835.64
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	78,008,219,977.00	78,008,219,977.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(35,567,839,084.79)	(36,186,439,590.67)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	581,027,816,126.74	526,554,669,252.31
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,051,266,116,729.56	1,010,799,682,961.08

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	311,499,629,903.73	319,326,128,173.29
2	Борлуулалтын өртөг	313,256,103,399.91	324,811,782,578.46
3	Нийт ашиг(алдагдал)	(1,756,473,496.18)	(5,485,654,405.17)
4	Түрээсийн орлого	180,717,356.62	173,163,206.81
5	Хүний орлого	2,733,639.77	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	4,117,760,939.02	11,936,390,625.73
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,140,421,864.94	2,661,113,881.52
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,827,102,800.71	4,722,963,200.95
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	4,485,336,645.01	9,632,898,019.69
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	32,415,627,392.97	(39,583,806,928.28)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(4,493,011,984.90)	(77,912,837.75)

15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	19,014,492,536.64	(50,054,795,440.82)
19	Орлогын татварын зардал	1,184,714,132.19	354,793,196.17
20	Татварын дараах ашиг (алдагдал)	17,829,778,404.45	(50,409,588,636.99)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	17,829,778,404.45	(50,409,588,636.99)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	107,919,748,900.04	312,961,105,414.66	78,008,219,977.00	(31,229,114,618.89)	467,659,959,672.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(22,168,502,870.35)	(22,168,502,870.35)
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	17,829,778,404.45	17,829,778,404.45
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	119,151,991,130.30	-	-	-	119,151,991,130.30
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(1,445,410,210.47)	-	-	(1,445,410,210.47)
2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	227,071,740,030.34	311,515,695,204.19	78,008,219,977.00	(35,567,839,084.79)	581,027,816,126.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(4,063,558,237.44)	(4,063,558,237.44)
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(50,409,588,636.99)	(50,409,588,636.99)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(53,854,546,368.55)	-	53,854,546,368.55	-
2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	227,071,740,030.34	257,661,148,835.64	78,008,219,977.00	(36,186,439,590.67)	526,554,669,252.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	284,408,100,391.64	315,579,289,623.55
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	277,827,302,009.92	313,025,288,930.61
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	6,580,798,381.72	2,554,000,692.94
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	270,604,336,273.50	311,680,122,119.25
1.2.1	Ажиллагчдад төлсөн	37,346,046,230.21	41,062,094,795.80
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	13,113,865,781.16	14,191,558,216.98
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	131,115,200,000.00	142,172,303,781.02
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	-
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	34,900,738,631.08	52,181,388,814.12
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	6,779,096,613.45	16,770,121,772.37
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	20,278,275,595.68	17,228,338,649.18
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	78,798,026.00	98,524,766.67
1.2.9	Бусад мөнгөн зарлага	26,992,315,395.92	27,975,791,323.11
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,803,764,118.14	3,899,167,504.30
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,733,639.77	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.2.6	Хүлээн авсан хүүгийн орлого	2,733,639.77	-
2.2.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	25,741,573,568.49	4,851,440,872.48
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,440,112,448.00	1,995,323,066.02
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	21,301,461,120.49	2,856,117,806.46
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(25,738,839,928.72)	(4,851,440,872.48)

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	28,300,157,046.86	2,874,876,083.46
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	28,300,157,046.86	2,874,876,083.46
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,098,292,338.64	5,079,530,958.90
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	10,098,292,338.64	1,513,610,958.90
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	3,565,920,000.00
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,201,864,708.22	(2,204,654,875.44)
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,266,788,897.64	(3,156,928,243.62)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,778,942,276.43	9,045,731,174.07
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,045,731,174.07	5,888,802,930.45

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 он		Зөрүү		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	гүйц-төл	хувь	
1	Боловсруулсан	ЦЭХ	сая кВт.ц	4,538.7	4,425.1	4,637.6	212.5	104.8%
		ДЭХ	мян.Гкал	4,172.1	4,404.7	4,551.4	146.7	103.3%
	Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний зарцуулалт	хувиар	хувь	11.23	11.50	11.34	(0.2)	98.6%
		биетээр	сая кВт.ц	509.8	508.9	526.1	17.2	103.4%
	Эрчим хүч түгээлт	ЦЭХ	сая кВт.ц	4,028.9	3,916.2	4,111.5	195.3	105.0%
		ДЭХ	мян.Гкал	4,172.1	4,404.7	4,551.4	146.7	103.3%
2	Нийт орлого	сая төг	348,222.2	305,329.8	331,435.7	26,105.8	108.6%	
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	311,499.6	301,246.4	319,326.1	18,079.8	106.0%	
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	36,722.6	4,083.5	12,109.6	8,026.1	296.5%	
3	Нийт зардал	сая төг	329,207.7	335,420.5	381,490.5	46,070.0	113.7%	
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал	сая төг	322,578.0	332,052.7	336,958.6	4,905.9	101.5%	
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	6,629.7	3,367.8	44,531.9	41,164.1	1222.3%	
	Үүнээс: валютыг ханшийн бодит бус ашиг/алдагдал	сая төг	32,415.6		(39,583.8)		100.0%	
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая төг	19,014.5	(30,090.7)	(50,054.8)	(19,964.1)	166.3%	
5	Татварын дараах ашиг /алдагдал/	сая төг	17,829.8	(30,090.7)	(50,409.6)	(20,318.9)	167.5%	
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төг	0.95	1.10	1.05	0.05	95.6%	
7	Нийт авлага	сая төг	31,804.1	7,366.5	19,604.3	12,237.8	266.1%	
	Үүнээс: ЭХ-ний	сая төг	31,334.2	6,966.5	17,094.4	10,127.9	245.4%	

		бусад	сая төг	469.9	400.0	2,509.8	2,109.8	627.5%
8	Нийт өглөг		сая төг	470,238.3	408,520.8	484,245.0	75,724.2	118.5%
	Үүнээс:	УХӨТ	сая төг	367,926.3	367,926.3	329,338.3	(38,588.0)	89.5%
		БХӨТ	сая төг	102,312.0	40,594.5	154,906.7	114,312.2	381.6%
9	Нийт ажиллагсад		тоо	1,480	1,487	1,487	0.0	100.0%
10	Нийт цалингийн сан		сая төг	46,845.7	50,674.8	49,900.0	(774.8)	98.5%
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	цахилгаан	гр/кВт.ц	270.90	275.02	270.88	(4.1)	98.5%
		дулаан	кг/Гкал	172.17	172.51	171.66	(0.8)	99.5%
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая төг	23,217.2	36,746.7	27,005.8	(9,740.9)	73.5%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь эрхэм зорилгоо “Эх орны хөгжлийн баталгаа, эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байна” гэж тодорхойлжээ.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь тайлант онд ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшинг 70 хувьд хүргэх, ажилтнуудын чадамжийн дундаж түвшинг 0.05-аар дээшлүүлэх, “4S”-ийн түвшин хангасан ажлын байрны тоог нэмэгдүүлэх, үндсэн тоноглолын тасралтгүй ажиллах дундаж цагийг 1104-д хүргэх, түлшний хувийн зарцуулалтыг 1425 ккал/кВтц хүргэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг “цахилгааны, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, худалдах” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 70 хувь, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 30 хувийг эзэмшиж байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийг Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолыг үндэслэн бие даасан төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн өөрчлөн зохион байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг ТУЗ-ийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.8 дах заалт “Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох”, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дах заалт “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” гэсэн заалтуудтай нийцэж байна.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоосон хэмжээ нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр баталсан;
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- ЗГ-ын 2021 оны 388 дугаар “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2022 оны 340 дүгээр “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Эрчим хүчний Яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2022 оны санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн байна.

Хяналтын албаны санхүүгийн хяналтын дотоод аудитор нь тайлант онд хийх ажлын төлөвлөгөөг 5 чиглэлд нийт 18 ажил хийхээр батлуулж, үүнээс 4 чиглэлийн 14 ажлыг 100.0 хувь, 1 чиглэлийн 1 ажлыг 85 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн байна.

Дотоод хяналтын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын ажилтны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын ажилтнаас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 оны 12 дугаар сард ТУЗ-ийн тогтоолоор баталсан байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,466.4 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар *буурсан* байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,045,731.2	5,888,802.9	(3,156,928.3)

Авлага	31,804,115.6	19,604,250.0	(12,199,865.6)
Бараа материал	19,376,776.8	29,111,126.0	9,734,349.2
Урьдчилж төлсөн зардал	1,649,758.3	6,629,612.3	4,979,854.0
Үндсэн хөрөнгө	989,389,735.0	949,565,891.8	(39,823,843.2)
Нийт хөрөнгө	1,051,266,116.7	1,010,799,683.0	(40,466,433.7)
Өр төлбөр	470,238,300.6	484,245,013.7	14,006,713.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	581,027,816.1	526,554,669.3	(54,473,146.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,051,266,116.7	1,010,799,683.0	(40,466,433.7)

Касс дахь бэлэн мөнгө 1.3 сая төгрөг, банк дахь харилцах данс 5,887.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 19,604.3 сая төгрөг болж 12,199.9 сая төгрөгөөр буурахад борлуулалтын авлага дансны бууралт ихээхэн нөлөөлсөн байна. Авлагын үлдэгдлийг насжилтаар нь авч үзвэл хэвийн 20,170.7 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 321.9 сая төгрөгийн авлага байна. Найдваргүй авлагыг нөөцийн буюу хасагдуулгын аргаар тооцдог байна. Тайлант онд 888.3 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулсан байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 321.9 сая төгрөгийн бусдаас авах авлага байна. Энэ нь харилцагч байгууллагууд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтоолтой, холбоо тогтоох боломжгүй зэрэг асуудлаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 29,111.1 сая төгрөг болж 9,734.3 сая төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгсэл болон нүүрсний худалдан авалтаас ихээхэн шалтгаалжээ.

Бараа материал данс нэмэгдэхэд тайлант онд худалдан авалтаар 197,504.9 сая төгрөг, тооллогоор илүүдсэн 1,516.2 сая төгрөгийн бараа материалыг орлого авсан нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 4,268.3 сая төгрөгийн бэлдэц бронз, булан, вентиль, даралтын хэмжүүр, холхивч, домбон холхивч, кольцо, резин, үрлэн холхивч, хамгаалах клапан, тохируулах клапан, цахилгаан хөдөлгүүр, шибер, эрвээхэй хаалтын редуктор, труба, шугам хоолой, цагариган жийргэвч зэрэг бараа материал байна. Энэ нь өмнөх онуудад бэлтгэсэн аваарын нөөц болон хуучин тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэлтэй холбоотой байна. Эдгээр бараа материалд 746.0 сая төгрөгийн бараа материалын үнэ цэний бууралт бүртгэсэн байна.

Оны эцэст 20,715.3 сая төгрөгийн нүүрсний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 6,629.6 сая төгрөг болж 4,979.9 сая төгрөгөөр өссөн нь нүүрс болон төмөр замын тээврийн урьдчилгаа шилжүүлснээс ихээхэн шалтгаалжээ.

Тайлант онд ажлын төлбөрт 12,023.7 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлж, ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 11,972.4 сая төгрөгийг зардалд хүлээн зөвшөөрсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 39,823.8 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үндсэн хөрөнгө шинээр худалдан авсан 1,995.3 сая төгрөг, их засварын зардал 20,309.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, ТӨБЗГ-ын 2022 оны 356, 463 дугаар тогтоолоор 286.1 сая төгрөгийн анхны өртөгтэй, 208.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 2 ширхэг хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл 34.5 сая төгрөгөөр өссөн нь сүлжээний мониторингийн сервер худалдаж авсан дүнгээр нэмэгдсэн байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдэл 409.3 сая төгрөгийн засварын ажлын хөлс, бараа материалын өссөн байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 154,906.7 сая төгрөг болж 52,594.7 сая төгрөгөөр өссөн нь богино хугацаат зээлийн үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 329,338.3 сая төгрөг болж 38,588.0 сая төгрөгөөр буурсан нь урт хугацаат зээлийн ангилал шилжүүлж богино хугацаат зээл рүү шилжүүлсэнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 1998-2022 онуудад Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Сангийн яам, Хөгжлийн банкнаас Турбоагрегат 1,2,3,4-ийг шинэчлэх, эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байгаатай холбоотой авсан нийт 289,995.7 сая төгрөгийн зээл байна. Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэж чадахгүй байгаа шалтгаан нь эрчим хүч борлуулах үнэ тарифт Төрийн захиргааны байгууллагын тогтоосон зохицуулалттай үнэ тарифыг мөрдөж, орлогын эх үүсвэрт зээлийн төлөлт тусгагдаагүйгээс болсон байна. Энэ нөхцөл байдал урт хугацаагаар үргэлжилбэл төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж, санхүүгийн хүндрэлд оруулж болзошгүй үр дагавартай байна

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь Хөгжлийн банкнаас 2018-2022 онуудад 77.5 сая евро буюу 270,654.5 сая төгрөгийн зээлийг Турбоагрегат 1,2,3,4-ийг шинэчлэх, 2015 онд 12.1 сая ам.доллар буюу 33,634.7 сая төгрөгийн зээлийг “Дулааны IV цахилгаан станц” ТӨХК-ийн хүчин чадлыг 123Мвт-аар нэмэгдүүлэх зориулалттай авч, зээлийг Турбоагрегат 1,2,3,4-ийг шинэчлэх болон станцын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зориулалтын дагуу зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт 12.1 сая ам.доллар, 1.6 сая евро, зээлийн үлдэгдэл 75.9 сая евро буюу 278,586.8 сая төгрөг байна

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлыг эдийн засгийн үр ашгийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлж байгаа бөгөөд хэмжиж болохуйц байвал хүлээн зөвшөөрнө, төлсөн, эсвэл төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжинэ гэж заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Нийт зардал өмнөх онтой харьцуулахад 46,070.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гадаад валютын ханшийн өсөлтийн нөлөөлөл 39,583.8 сая төгрөг, боловсруулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ өмнөх онтой харьцуулахад 4.8 хувиар, үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчний хэмжээ 3.3 хувиар өссөнтэй холбоотойгоор зарцуулсан түлш, материалын зардал, цалингийн зардал, үйлдвэрийн ашиглалтын зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэхтэй холбоотой шууд материалын зардал буюу зарцуулсан түлш, түүхий эд материалын зардал, шууд хөдөлмөрийн зардал болох цалингийн зардал болон ашиглалтын зардал, элэгдлийн зардал, зээлийн хүүгийн зардал, хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал, зохицуулалтын үйлчилгээний зардал зэрэг зардлуудыг хамруулсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2022 оны 11 дүгээр тушаалаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 304,694.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 334,785.3 сая төгрөгөөр, 30,090.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 29,159.2 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Эрчим хүчний сайдын 2022 оны 130, 204 дүгээр тушаалаар нийт орлогыг 635.1 сая төгрөг, нийт зардлыг 635.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтын арга хэмжээг 7,587.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 331,435.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 381,490.5 сая төгрөгийн зардал гарган, 50,054.8 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 331,435.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 26,105.8 сая төгрөг буюу 8.6 хувиар давсан нь боловсруулсан цахилгаан эрчим хүчийн хэмжээ 4.8 хувь, дулааны эрчим хүчийн хэмжээ 3.3 хувиар өссөнөөс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 381,490.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 46,070.0 сая төгрөг буюу 13.7 хувиар хэтэрсэн байна. Энэ нь гадаад валютын ханшийн зөрүүгийн нөлөөлөл болон цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн хэмжээ өссөнөөс болж зарцуулсан түлш, материалын зардал, цалингийн зардал, үйлдвэрийн ашиглалтын зардал нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 5 нэр төрлийн 284 ажилд өөрийн эх үүсвэрээс 27,005.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 50,409.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 20,318.9 сая төгрөгөөр илүү байгаа нь үйл ажиллагааны бус зардал болох гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз нөлөөлжээ.

ТӨБЗГ-т тайлант онд ногдол ашгийн 3,565.9 сая төгрөг, түрээсийн орлогын 40 хувь буюу 68.8 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах шилэн дансны мэдээлэл, худалдан авах үйл ажиллагаа, дансны өглөгийн үлдэгдэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мүүрь аудит ХХК-ийн менежер Н.Дагийрагчаа, аудитор Ч.Жаргалдулам, Ж.Сүрэнхорлоо, аудитын туслах М.Солонго нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Н.Гэрэлчимэг, Мэргэжлийн үйлчилгээ хариуцсан захирал У.Оюунаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/136 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тогтоох эх сурвалжийг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтээр борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлого 311,499.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3,114.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага дэд дарга, орлогчийн орон тоог цомхотгох, гүйцэтгэх удирдлагуудын автомашиныг шилжүүлэх, шинээр баригдахаар төлөвлөгдсөн барилгын ажлыг хориглох, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөгдсөн зарим ажлын хасах, холбоо, хэвлэл, дотоод албан томилолт, спортын зардлыг хэмнэх, баяр ёслол, ой тэмдэглэх зэрэг зардлыг хориглох зэрэг арга хэмжээ авсан байна .

Энэ хуулийн хүрээнд дэд дарга, орлогчийн орон тоог хассанаар 135.9 сая төгрөгийн цалингийн зардал, хөдөлмөр хамгаалал, бичиг хэргийн зардал, албан тушаалын автомашинтай холбоотой 11.5 сая төгрөгийн урсгал засвар, сэлбэг, шатахууны зардал, нийт 147.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь тайлант онд нийт 1,232,649.0 сая төгрөгийн 4205 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 45.7 сая төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй, 10,791.7 сая төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулж байх албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТУЗ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 45,520.1 сая төгрөгийн худалдан авалтын төлөвлөгөөг баталсан байна. ТУЗ-ийн 17 дугаар тогтоолоор 16,462.4 сая төгрөгөөр худалдан авалтын төлөвлөгөөг нэмэгдүүлэх тодотгол хийсэн байна. Тайлант онд 142 удаагийн 41,440.5 сая төгрөгийн нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг цахимаар хийж, 129 удаагийн 13,091.4 сая төгрөгийн худалдан авалтыг үнийн харьцуулалтын аргаар хийж, төсөвлөснөөс 2,411.6 сая төгрөг хэмнэсэн байна.

Тайлант оны эцэст тендерийг үнэлж гэрээ байгуулах шатанд 13 удаагийн 5,436.2 сая төгрөгийн нээлттэй тендер сонгон шалгаруулалт хүлээгдэж байгаа бөгөөд тайлант жил тендер сонгон шалгаруулалт зарласан боловч амжилтгүй болсон, оролцогч байхгүй зэрэг шалтгаанаар хойшилсон нийт 6 худалдан авалт цуцлагдсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авалтын үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 5,901.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 199.7 сая төгрөгийг залруулж, 5,698.9 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 3.2 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 16.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 834.8 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 5.4 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснөөс төлбөрийн актын хэрэгжилт 100.0 хувь, албан шаардлагын хэрэгжилт 83.3 хувь, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	16,133.3	1	16,133.3	100
Албан шаардлага	6	834,778.7	5	773,615.2	83.3
Зөвлөмж	1	5,385.0	1	5,385.0	100
Нийт дүн	8	856,297.0	7	795,133.5	94.4

/мянган төгрөгөөр/

Авлагын үлдэгдлийг тулган баталгаажуулах алдаанд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлтийг зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу хийж байгаа эсэхийг дараагийн аудитаар шалгах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,454.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,931.3 сая төгрөгийн алдааг залруулж, 523.5 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,931.3 сая төгрөгийн 8 алдааг залрууллаа. Үүнд:

- НББОУС-1-ийн 88 дугаар зүйлтэй нийцээгүй, урьдчилж төлсөн тооцоо дансанд зардалд хуваарилагдах 21.8 сая төгрөгийн зардлыг бүртгэсэн;
- НББОУС-26-ын 17 дугаар зүйлтэй нийцээгүй, ажилчдын тэтгэврийн нөөц өр төлбөрийн тооцоололтой холбоотой тэтгэмжийн зардлыг 493.0 сая төгрөгөөр дутуу тооцоолсон;
- НББОУС-2-ын 9 дүгээр зүйлтэй нийцээгүй, ашиглагдахгүй байгаа бараа материалын үлдэгдэлд 746.0 сая төгрөгийн бараа материалын үнэ цэнийн бууралт тооцоогүй;
- НББОУС-12-ын 15 дугаар зүйлтэй нийцээгүй, хойшлогдсон татварын өр төлбөрийг 440.2 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- НББОУС-21-ийн 21 дүгээр зүйлтэй нийцээгүй, гадаад валютын ханшийг зөрүүтэй бүртгэснээс зээлийн хүүгийн төлөлтийг 6.0 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- НББОУС-21-ийн 23 дугаар зүйлтэй нийцээгүй, гадаад валютаар илэрхийлэгдсэн дансны өглөгийн үлдэгдэлд 109.6 сая төгрөгийн ханшийн тэгшитгэл хийгээгүй;
- ХХОАТ-н өглөгийн үлдэгдлийг татварын тайлангийн үлдэгдлээс 97.8 сая төгрөгөөр илүү бүртгэсэн;

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орсон ажилтанд нөхөн олгосон 16.9 сая төгрөгийн цалин хөлс, НДШ-ийн зардлыг өмнөх үеийн хуримтлагдсан ашиг дансанд бүртгэсэн.

Аудитаар нийт 81,260.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 5.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 81,254.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 81,784.1 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 3,114.9 сая төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд 2 ажилтанд батлагдсан цалингаас 5.8 сая төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн “Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг”-ийн 1.4 “Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, 20.2.4 “Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актаас 5.4 сая төгрөгийг ажилчдаас дутуу суутгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 “Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн актыг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэх

Хөгжлийн банкны зээлийн өмнөх болон тайлант оны үндсэн төлөлт 80,982.4 сая төгрөгийг төлөөгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 “Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх”, Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 “Төсвийн хэрэгжилтэд хяналт тавих;”, 10.1.11 “Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах;” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зээл, өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэх

Авлагын дансны 232.8 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, гуравдагч талаар тулган баталгаажуулахад тулган баталгаажуулах захидлын хариу ирүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх, барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэх

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өглөгийн дансны 34.2 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, гуравдагч талтай тулган баталгаажуулахад харилцагчаас үлдэгдэл баталгаажиж ирээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх, барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авах бараа, ажил үйлчилгээний талаар цахим дэлгүүрт байршуулаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалттай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цахим дэлгүүрт 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг байршуулдаг байх.

2. Дансны өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өглөг дансанд ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан баталгааны хугацаа дууссан 523.5 сая төгрөгийн баталгааны үлдэгдэл бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ;” гэсэн заалтуудтай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Баталгааны хугацаа дууссан дансны өглөгийг удирдлагын шийдвэрийн дагуу холбогдох дээд байгууллагын дансанд татан төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Урьдчилж төлсөн тооцоо дансанд зардалд хуваарилагдах зардлыг бүртгэсэн.	1	21,822.9			1	21,822.9	1	21,822.9				
Ажилчдын тэтгэврийн нөөц өр төлбөрийн тооцоололтой холбоотой тэтгэмжийн зардлыг дутуу тооцоолсон.	1	492,952.8			1	492,952.8	1	492,952.8				
Ашиглагдахгүй байгаа бараа материалын үлдэгдэлд бараа материалын үнэ цэнийн бууралт тооцоогүй.	1	745,996.9	1	745,996.9			1	745,996.9				
Хойшлогдсон татварын өр төлбөрийг дутуу бүртгэсэн.	1	440,181.6			1	440,181.6	1	440,181.6				
Гадаад валютын ханшийг зөрүүтэй авснаас зээлийн хүүгийн төлөлтийг дутуу бүртгэсэн.	1	6,042.5			1	6,042.5	1	6,042.5				
Гадаад валютаар илэрхийлэгдсэн дансны өглөгийн үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийгээгүй.	1	109,567.0	1	109,567.0			1	109,567.0				
ХХОАТ-н өглөгийн үлдэгдлийг татварын тайлангийн	1	97,841.2			1	97,841.2	1	97,841.2				

үлдэгдлээс илүү бүртгэсэн												
Шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орсон ажилтанд нөхөн олгосон цалин хөлс, НДШ-ийн зардлыг өмнөх үеийн хуримтлагдсан ашиг дансанд бүртгэсэн	1	16,908.8		1	16,908.8		1	16,908.8				
Ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан баталгааны хугацаа дууссан баталгаа дансны өглөг дансанд бүртгэлтэй байна.	1	523,529.9							1	523,529.9	1	523,529.9
Дүн	9	2,454,843.6	2	855,563.9	6	1,075,749.8	8	1,931,313.7	1	523,529.9	1	523,529.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 2 ажилтанд батлагдсан цалингаас илүү цалин олгосон байна.	1	5,844.7	1	5,844.7								
Өмнөх оны аудитаар тогтоосон актыг ажилчдаас дутуу суутгасан байна.	1	5,419.2			1	5,419.2						
Хөгжлийн банкны зээлийн өмнөх болон тайлант оны үндсэн төлөлтийг төлөөгүй байна.	1	80,982,367.7			1	80,982,367.7						
Авлагын дансыг гуравдагч талаар тулган баталгаажуулахад тулган баталгаажуулах захидлын хариу ирээгүй байна.	1	232,828.9			1	232,828.9						
Өглөгийн дансыг гуравдагч талтай тулган баталгаажуулахад баталгаажиж ирээгүй.	1	34,178.3			1	34,178.3						
Дүн	5	81,260,638.8	1	5,844.7	4	81,254,794.1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансанд оруулбал зохих 16 мэдээллийн хугацаа хоцроож, 4 мэдээллийг оруулаагүй байна.	1	-			1	-		
Худалдан авах бараа, ажил үйлчилгээний талаар цахим дэлгүүрт байршуулаагүй байна.	1	-					1	-
Дүн	2	-			1	-	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 дугаар сарын 21 № 153/А0150116

Улаанбаатар хот

СНАГ-2023/106/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь 2 ажилтанд 5,844,674.07 төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, 20.2.4 “Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл “Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг”-ийн 1.4 “Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий ажилтнуудад илүү олгосон 5,844,674.07 (таван сая найман зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун далан дөрвөн төгрөг долоон мөнгө) төгрөгийг нөхөн төлүүлж, Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 9 сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нэрт хариуцуулав.


ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Я.САМБУУНЯМ

У.ОЮУНАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2023\0315 SNAG-51.Docx

0001090150



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 572/А0150116

Улаанбаатар хот

СНАГ-2023/106/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актаас 5,419,188.64 төгрөгийг ажилчдаас дутуу суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 “Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх;” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, 5,419,188.64 /таван сая дөрвөн зуун арван есөн мянга нэг зуун наян найман төгрөг жаран дөрвөн мөнгө/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.САМБУУНЯМ

МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

У.ОЮУНАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 573 / А 0150116

Улаанбаатар хот

СНАГ-2023/106/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь Хөгжлийн банкны зээлийн өмнөх болон тайлант оны үндсэн төлөлт 80,982,367,701.79 төгрөгийг төлөөгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн "15.2.5.хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Хөгжлийн банкны хуваарийн дагуу төлж барагдуулах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.САМБУУНЯМ

МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

У.ОЮУНАА



0001081271



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 574/АОУСО116

Улаанбаатар хот

СНАГ-2023/106/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авлагын дансны 232,828,872.95 төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх, барагдуулах арга хэмжээ авах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.САМБУУНЯМ

МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

У.ОЮУНАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 545/А0150116

Улаанбаатар хот

СНАГ-2023/106/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өглөгийн дансны 34,178,330.83 төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх, барагдуулах арга хэмжээ авах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МӨРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Я.САМБУУНЯМ

У.ОЮУНАА

0001081758



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 576/А0150116
СНАГ - 2023/106/НА-СТА-ТВА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 4205 мэдээллээс 16 мэдээллийг хугацаа хоцроож, 45,678,002.99 төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх,” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг үнэн зөв, ил тод, хуулийн хугацаанд байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Я.САМБУУНЯМ

У.ОЮУНАА